# 2013 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2013 оны 5 дугаар сарын 20

## 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2013 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

/тоогоор/

| № | Тусгай зөвшөөрөл эзэмшигчид | 2013.03.31 | Нэмэгдсэн | Хасагдсан | 2013.04.30 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Даатгалын компани | 17 | | | 17 |
| 2 | Даатгалын компанийн салбар | 219 | 11[1] | | 230 |
| 3 | Даатгалын төлөөлөгч | 2438 | 277[2] | 17[3] | 2698 |
| 4 | Даатгалын зуучлагч | 18 | 1[4] | | 19 |
| 5 | Даатгалын хохирол үнэлэгч | 10 | | | 10 |
| 6 | Актуарч | 15 | | | 15 |
| 7 | Бусад | 16 | | | 16 |

[1]Хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 76 дугаар тушаалаар "Бодь даатгал" ХХК-д Архангай аймгийн Эрдэнэбулган, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Дундговь аймгийн Сайнцагаан, ТӨВ аймгийн Зуунмод, Дорноговь аймгийн Замын-Үүд сумуудад, Улаанбаатар хотын Багануур дүүрэгт, Хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 82 дугаар тушаалаар "Монре даатгал" ХХК-д Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, Баянзүрх дүүрэг, Хан-Уул дүүрэг, Сонгино хайрхан дүүргийн нутаг дэвсгэрт, Хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 97 дугаар тушаалаар "Улаанбаатар хотын даатгал" ХХК-д Дархан уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт тус тус даатгалын үйл ажиллагаа эрхлэх салбар нээн ажиллуулахыг зөвшөөрөх шийдвэр гаргасан байна.

[2]Хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 86 дугаар тушаалаар "Соёмбо даатгал" ХХК-ийн 18 иргэнд, "Монре даатгал" ХХК-ийн 1 иргэнд, Хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 95 дугаар тушаалаар "Практикал даатгал" ХХК-ийн 11 иргэнд, 2013 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 96 дугаар тушаалаар "Соёмбо даатгал" ХХК-ийн 27 иргэнд, Хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 98 дугаар тушаалаар "Бодь даатгал" ХХК-ийн 88 иргэнд, Хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 99 дүгээр тушаалаар "Ард даатгал" ХХК-ийн 42 иргэнд, 2013 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 100 дугаар тушаалаар "Тэнгэр даатгал" ХХК-ийн 65 иргэнд, мөн өдрийн 101 дүгээр тушаалаар "Ард даатгал"ХХК-ийн 25 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгосон байна.

3 Хорооны даргын 2013 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалаар "Миг даатгал" ХХК, "Номин даатгал" ХХК, "Нэйшнл лайф даатгал" ХХК, "Практикал даатгал" ХХК, "Монгол даатгал" ХХК, "Гэр даатгал" ХХК-иудын 17 иргэний даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон байна.

[4]Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 175 дугаар тогтоолоор "Хадгаламж банк" ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

## 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2013 оны 04 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд болон өссөн дүнгээр харуулбал:

**Ердийн даатгалын компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.04.30 /сарын дүн/ | 2013.04.30 /өссөн дүн/ |
|---|---|---|
| Даатгалын нийт хураамж | 6,001,896,619.54 | 20,619,339,132.49 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж | 1,632,106,590.46 | 3,205,198,622.54 |
| Олгосон нийт нөхөн төлбөр | 1,960,503,862.83 | 8,556,735,917.69 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр | 658,230,460.00 | 3,522,923,360.80 |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо | 1,786.00 | 7,568.00 |
| Давхар даатгалд төлсөн хураамж | 611,892,074.88 | 5,916,797,403.08 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо | 50,847.00 | 106,261.00 |
| Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо | 32,419.00 | 62,446.00 |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо | 35,794.00 | 68,821.00 |
| Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 488,139,112,208.00 | 488,139,112,208.00 |
| Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр | 57,193,246.72 | 256,077,456.49 |

2013 оны 4 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 20619.4 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 3205.2 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 8556.7 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 3522.9 сая төгрөг болсон байна. Эндээс хохирол нөхөлтийн түвшин сарын байдлаар 32.6 хувь, өссөн дүнгээр 41.5 хувь болсон бөгөөд өмнөх сарын мөн үеийнхээс өссөн дүнгээр 4 пунктээр буурсан байна.

**Урт хугацааны даатгалын компанийн хувьд :**

**/Төгрөгөөр/**

| Үзүүлэлт | 2013.04.30 /сарын дүн/ | 2013.04.30 /өссөн дүн/ |
|---|---|---|
| Даатгалын нийт хураамж | 48,637,860.00 | 279,517,046.00 |
| Олгосон нийт нөхөн төлбөр | 23,842,592.30 | 47,234,198.30 |
| Давхар даатгалд төлсөн хураамж | 841,428.00 | 2,612,482.00 |
| Байгуулсан даатгалын гэрээний тоо | 7 | 66 |
| Хувь хүний хугацаат даатгалд | | 6 |
| Байгууллагын хугацаат даатгалд | | 6 |
| Өндөр хамгаалалттай ЭМД-д | 2 | 4 |

| | | |
|---|---|---|
| Эмнэлгийн мөнгөний даатгалд | | 14 |
| Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд | 1 | 10 |
| Тэтгэврийн даатгалд | 2 | 15 |
| Орон сууцны даатгалд | | 2 |
| Хуримтлалын даатгалд | | 3 |
| Зээлдэгчийн амь насны даатгалд | 2 | 11 |
| Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 3,000,000,000.00 | 3,000,000,000.00 |
| Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн | 11,229,913.00 | 11,229,913.00 |

Урт хугацааны даатгагч 2013 оны 4 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ 279.5 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой, 47.2 сая төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Өмнөх оны мөн үеийн 4 дүгээр сарын дүнтэй харьцуулбал хураамжийн орлого 20.1 сая төгрөгөөр буурч, нөхөн төлбөр 16.8 сая төгрөгөөр өсчээ.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2013.04.30 /сарын дүн/ | 2013.04.30 /өссөн дүн/ |
|---|---|---|
| Нийт орлого | 20,587,262.32 | 92,248,038.85 |
| Даатгалын зуучлагчийн орлого | 20,473,122.32 | 91,088,733.90 |
| Үүнээс: Сайн дурын даатгал | 17,250,287.02 | 79,114,663.45 |
| Албан журмын даатгал | 3,222,835.30 | 6,493,624.05 |
| Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж | 39,323,245.19 | 138,128,756.23 |
| Зуучилсан даатгалын гэрээний тоо | 308 | 1,009.00 |
| Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ | 4776,365,700 | 31,929,161,910.00 |

2013 оны 4 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 92.2 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 85.7 хувийг сайн дурын даатгалаас, үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Асимон брокерс” ХХК-ийн зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Пийс оф лайф” ХХК, “Жомолхари” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Лояалти солюшн” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

“Си эн эн икс” ХХК, “Изи инвестмэнт” ХХК,  ХХК, “Нэйшнл эженси” ХХК “Хасбанк”ХХК-иуд тус тус 4 дүгээр сарын мэдээг тус тус ирүүлээгүй байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2012.04.30 /сарын дүн/ | 2012.04.30 /өссөн дүн/ |
|---|---|---|
| **Нийт орлого** | 32,040,800.00 | 125,749,055.00 |
| **Даатгалын хохирол үнэлгээний орлого** | 11,712,268.00 | 39,025,008.00 |
| **Үүнээс: Сайн дурын даатгал** | 4,471,677.09 | 15,423,904.82 |
| **Албан журмын даатгал** | 7,240,590.91 | 23,601,102.18 |
| **Үнэлсэн даатгалын хохирлын тоо** | 969.00 | 3,460.00 |
| **Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн** | 45,598,724.00 | 110,562,416.00 |

2013 оны 4 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 125.8 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс 39.5 хувийг сайн дурын, 60.5 хувийг албан журмын даатгалын хохиролын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

"Хөрөнгийн үнэлгээний төв" ХХК, "Мега марз" ХХК, "Гэрэгэ эстимэйт" ХХК, "Файн эстимэйт" ХХК-иуд тус тус 4 дүгээр сарын мэдээг ирүүлээгүй байна.

**БУСАД**

Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 138 дугаар тогтоолоор "Монре даатгал" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрсөн байна. Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 24 -ний өдрийн 172 дугаар тогтоолоор "Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийг хүчингүй болгосон өөрчлөлт орсон байна. "Хорооны 2011 оны 331 дүгээр тогтоолоор батлагдсан "Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам"-д өөрчлөлт орсон. Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор "Монгол улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага"-ыг хавсралтаар шинэчлэн баталсан.

Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 10 -ны өдрийн 87 дугаар тушаалаар "Пийс оф лайф" ХХК-ийн, Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 93 дугаар тушаалаар "Си эн эн икс" ХХК-ийн, Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 94 дүгээр тушаалаар "Нэйшнл эженси" ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээнд тус тус өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай шийдвэр гаргасан байна.

ДААТГАЛЫН БОДЛОГО Т ӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС